Гурванбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96,161.4 мянган төгрөгөөр буюу 2,6 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	958,814.4	1,061,577.5	102,763.1
Мөнгөн хөрөнгө	619,175.1	633,916.0	14,740.9
Авлага	251,066.6	289,751.3	38,684.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	88,572.7	137,910.2	49,337.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,614,796.0	2,608,194.3	(6,601.7)
Үндсэн хөрөнгө	3,437,521.2	3,640,137.1	202,615.9
Хуримтлагдсан элэгдэл	(822,725.2)	(1,031,942.8)	(209,217.6)
Нийт хөрөнгө	3,573,610.4	3,669,771.8	96,161.4
Өр төлбөр	-	3,578.1	3,578.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,573,610.4	3,666,193.7	92,583.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,573,610.4	3,669,771.8	96,161.4

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 619,175.1 мянга, эцсийн үлдэгдэл 633,916.0 мянган төгрөг болж 14,740.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө	619,175,1	633,916,0	+14,740,9	30,3
Дүн	619,175,1	633,916,0	+14,740,9	30,3

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 619,175.1 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 134,582.1 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 161,427,8 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 131,409.1 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 206,496.0 мянган төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 251,066.6 мянга, эцсийн үлдэгдэл 289,751.3 мянган төгрөг болж 38,684.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	18,721.2	86,224.0	67,502.0
Хувь хүмүүсээс авах авлага	131,000.0	131,000.0	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	101,345.4	72,527.3	(28,818.1)
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
Дүн	251,066.6	289,751.3	38,684.7

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 25,0 хувь буюу 172,527.3 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 9,2 хувь буюу 26,543.1 мянган төгрөг ЗДТГ-ын авлага, 64,8 хувь буюу 187,679.5 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сан, 1,0 хувь буюу 3,001.4 мянган төгрөг нь ИТХ-ийн авлага байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	18,125.6	26,543.1	8,417.5	9,2
ИТХ	2,000.0	3,001.4	1,001.4	1,0
СХС	101,345.4	72,527.3	-28,818.1	25,0
ОНХСан	129,595.6	187,679.5	58,083.9	64,8
НИЙТ ДҮН	251,066.6	289,751.3	38,684.7	100.00

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 101,345.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тухайн онд зээл олгоогүй бөгөөд 28,818,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 72,527.3 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 885,726.6 мянга, эцсийн үлдэгдэл 137,910.1 төгрөг болж, 49,337.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	16,803.9	19,302.7	2,498.8
Эм боох материал	4,003.0	2,262.0	-1,741.0
Бичиг хэргийн материал	2,320.9	2,291.9	-29.0
Аж ахуйн материал	17,725.6	44,068.7	26,343.1
Сэлбэг хэрэгсэл	-	284.0	284.0
Бусад хангамжийн материал	47,719.2	64,023.0	16,303.8
Мал амьтад	-	5,677.7	5,677.7
Дүн	88,572.6	137,910.1	49,337.5

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 137.910.1 мянган төгрөг болж өмнөх оноос 49,337.5 мянган төгрөгөөр өссөн нь бичиг тусгай зориулалтын материал 2,498.8 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 26,343.1 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 284.0 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 16,303.8 төгрөгөөр, мал амьтад 5,677.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	1,407.8	3,472.8	2,465.0	1,6
ЗДТГ	87,164.8	134,437.3	47,272.5	98,4
НИЙТ ДҮН	88,572.6	137,910.1	49,337.5	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 208,017.6 мянган төгрөгийн бараа материалын төсвийн хөрөнгөөр, 82,431.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт 232,367.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 8,743,9 мянган төгрөг бараа материалыг бусад зарлагаар зарлагдсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	290,448.9	Хасагдсан	241,111.4
Худалдан авсан	208,017.6	Худалдсан, зарцуулсан	232,367.5
Хандиваар	82,431.3	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	
Шилжүүлсэн авсан		шилжүүлсэн	
бусад		бусад	8,743.9

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,437,521.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,640,137.1 мянган төгрөг болж 202,616.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	3,406,471.1	3,609,087.1	202,616.0	99,1
Барилга байгууламж, орон сууц	2,357,720.1	2,409,858.0	50,137.9	66.77

**Гурванбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тээврийн хэрэгсэл	224,827.8	233,674.5	8,846.7	6.47
Машин тоног төхөөрөмж	278,590.6	315,508.6	36,918.0	8.74
Тавилга эд хогшил	109,995.6	122,095.6	12,100.0	3.38
Номын фонд	1,254.5	1,254.5		0.03
Бусад үндсэн хөрөнгө	432,082.5	526,695.9	94,613.4	14.59
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	31,050.0	31,050.0	.0	0,9
Программ хангамж	2,950.0	2,950.0	0	9,5
Бусад биет бус хөрөнгө	28,100.0	28,100.0	0	90,5
НИЙТ ДҮН	3,437,521.1	3,640,137.1	202,616.0	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 23,643.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 203,130.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Нийт хасагдсан 24,157.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	26,730.1	29,230.1	2,500.0	0,8
ЗДТГ	3,410,791.0	3,610,907.0	200,116.0	99,8
НИЙТ ДҮН	3,437,521.1	3,640,137.1	202,616.0	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 202,616.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг орлого авсан голлох нөлөө үзүүлж байна

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	226,773.4	Хасагдсан	24,157.5
Худалдан авсан	23,643.0	Худалдсан	
Хандиваар	0.00	Акталсан	
Шилжүүлэн авсан		Шилжүүлсэн	24,157.5
бусад	203,130.4	Бусад	

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөр тайлант онд 3,578.1 мянган төгрөгөөр үүссэн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН				
Ажилчидтай холбогдсон өглөг				
Бараа үйлчилгээний зардлын өглөг				
Байгууллагад төлөх өглөг		3,578.1	3,578.1	100,0
Хувь хүмүүст өгөх өглөг				
Дүн	0	3,578.1	3,578.1	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНХС		3,578.1	3,578.1	100,0
ДҮН	0	3,578.1	3,578.1	100,0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,573,610.3 мянга, эцсийн үлдэгдэл 3,669,771.8 мянган төгрөг болж 92,583.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,921.6	235,921.6	0	6,6
Өмч: - төрйн				
Хуримтлагдсан үр дүн	3,320,889.2	3,413,472.6	92,583.4	92,9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,799.5	16,799.5		0,5
Дүн	3,573,610.3	3,669,771.8	92,583.4	100,0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.14-ны өдрийн хуралдааны 10/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 266,520.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6,000.0 мянга, нийт 272,520.0 мянган төгрөгөөр баталж, 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Сумын ИТХ-хуралдааны 14/01 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	272,520.0	483,985.8	200,762.5	173,6
ЦХТА орлого /суутган/	145,200.0	169,125.0	23,925.0	116,5
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	900.0	705.0	-195.0	78,3
Бууны татвар	5,820.0	3,450.0	-2,370.0	59,3
ИОТХ	18,000.0	15,644.1	-2,355.9	87,0
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	1,766.6	-233.4	88,3
Хадгаламжийн хүүгийн орлого	39,700.0	39,948.4	248.4	100,6
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	1,570.0	-1,430.0	52,3
Малын тоо толгойн албан татвар	30,000.0	30,037.6	37.6	100,1
Газрын төлбөр	19,000.0	3,413.5	-15,586.5	18,0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,400.0	12,317.5	3,915.5	146,7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		194,920.0	194,920.0	0
ТТАМАТөлбөр	500.0	189.6	-310.4	38,0
Газрын дуудлага худалдааны орлого	7,200.0	-	-7,200.0	-
Бусад татвар		195.0	195.0	
2.Татварын бус орлого	6,000.0	10,052.8	4,703.2	178,4
2.1.Хүү торгуулийн орлого	6,000.0	10,052.8	4,703.2	178,4
Нийт дүн	278,520.0	483,985.8	205,465.8	173,7

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 173,6 хувь буюу 200,762.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 23,925.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 248.4 мянга, малын тоо толгойн албан татвар 37.6 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,915.5 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 194,920.0 мянга, бусад татвар 195.0 мянга, хүү торгуулийн орлого 4,703.2 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 195.0 мянга, ИОТТХ-ийн албан татвар 2,355.9 мянга, галт зэвсгийн албан татвар 2,370.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 233.4 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,430.0 мянган төгрөг, газрын төлбөр 15,586.5 мянга, ТТАМАТөлбөр 310.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 11,800.0 мянган төгрөгийн орлого төлөвлөж 10,052.8 мянган төгрөгөөр биелүүлсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 36,980.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 28,818.1 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,950,188.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 1,497,623.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас, 1,189,615,3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 308,008.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Гурванбулаг сумын Засаг дарга	1,950,188.3	1,497,623.9	316,156.3	79.4
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	129,110.0	123,054.9	6,055.1	95,3%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	500.0	500.0	0	100%
4	82201 ГХУСАЗЗөвлөл зардал	6,656.0	6,607.3	48.7	99,3%
5	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	603,131.7	568,508.7	34,804.9	94,2%
6	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	100,181.6	98,050.1	2,131.4	97,9%
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	5,000.0	4,980.0	20.0	99.6%
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	39,28.5	39,204.0	80.5	99.8%
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	157,700.0	74,861.4	82,838.6	47,5%
10	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	8,400.0	7,234.5	1,165.5	86,1%
11	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	50,000.0	49,997.7	2.3	100,0%
12	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	33,767.0	32,102.5	1,664.5	95.1
13	71702 Соёл урлаг	54,982.6	49,880.0	5,102.4	90.7
14	71801 Сургуулийн өмнөх боловсрол	38,581.8	37,118.8	1,463.0	96.2
15	71802 Ерөнхий боловсрол	106,598.5	106,597.4	1.1	99.9
16	70503 Орон нутгийн зорилтот	91,907.0	93,977.1	-2,070.0	102.2

	орон оруулалт				
17	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	266,493.2	106,546.1	159,947.0	38,8
18	73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	6,342.1	6,342.1	0	100
19	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	30,000.0	19,443,0	10,557,0	64,81
20	83406 ОНХС -бусад	75,706,8	75,706,8	0	100
21	83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	5,993,4	5,993,4	0	100
22	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	139,670.0	100.0	139,570.0	0.07
	Нийт дүн	1,950,188.3	1,497,623.9	452,564.3	76.79

3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022.12.16-ний өдрийн 10/02 дугаар тогтоолоор нийт 1,687,049.5 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	75,024.0	121,344.5	-79,080.0
Засаг даргын Тамгын газар	373,799.8	759,080.2	-206,818.2
Сургууль	139,598.8	139,598.8	0.0
Цэцэрлэг	34,797.8	34,797.8	0.0
Эрүүл мэндийн төв	34,767.0	34,767.0	0.0
Соёлын төв	51,980.2	51,980.2	0.0
Сум хөгжүүлэх сан	0	134,310.0	-134,310.0
Орон нутгийн хөгжлийн сан	0	411,191.0	-411,191.0
Нийт дүн	866,376.8	1,687,049.5	909,328.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.16-ний өдрийн 10/02 дугаар тогтоолоор анх 1,687,049.5 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.06-ны өдрийн 14/01 дугаар тогтоолоор 263,138.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,950,188.3 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 354,535.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 641,978.8 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 285,720.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 11,800.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 619,174.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, сум хөгжүүлэх сангийн орлогоос 36,980.0 төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 641,978.8 мянга, орон нутгийн орлогоос 710,296.9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс

345,459.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 30,888.1 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 10,052.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 142,813.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	963,879.8	834,452.9	129,426.9	86.6	2,973.5
ИТХ	136,266.0	129,363.5	6,902.5	94.9	30,144.0
Соёлын төв	54,982.6	49,880.0	5,102.6	90.7	7,114.0
Сум хөгжүүлэх сан	139,670.0	100.0	139,570.0	0.1	
Сургууль	106,598.5	106,597.4	1.1	100.0	2,457.4
Цэцэрлэг	38,581.8	37,118.8	1,463.0	96.2	2,468.9
ЭМТ	33,676.0	32,102.5	1,573.5	95.3	11,223.2
ОНХС	476,442.6	308,008.6	168,434.0	64.6	-
Нийт дүн	1,950,097.3	1,497,623.7	452,473.6	76.8	56,381.1

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,497,623.9 мянган төгрөг буюу 76.79 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 129,426.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүгэж, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөсөн ажлууд хийгдээгүйгээс зардлыг 168,434.0 мянга, сум хөгжүүлэх сангаас зээл олгоогүйгээс 139,570.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.9.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 16,469.3 мянга, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 1,300.0, мянга, Аймгийн засаг даргын нөөцөөс 6,154.0 мянга, Аймгийн статистикийн хэлтсээс 2,729.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,286.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 16,469.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,800.0	33,096.7	34,896.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800.0	1,633.6	3,433.6
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,463.1	31,463.1
НИЙТ ЗАРЛАГА	798.6	8,383.6	9,182.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	798.6	8,383.6	9,182.2
Төсөвт төвлөрүүлсэн	1001.4	24,713.1	25,714.5

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 1/148 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Гурванбулаг сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг 2023 оны 1-11 саруудад Засаг дарга Б.Гантулга, 12 сард Засаг дарга Э.Жавхан, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга П.Тогтожжаргал нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 1,873,618.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,726.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,115.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 154 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Гурванбулаг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 39,423.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 22,579.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 2/111 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	22,579.2	1	22,579.2			100.0
Зөвлөмж	3	16,844.7	3	16,844.7			100.0
Нийт	4	39,423.9	4	39,423.9			100.0

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 39,284.5 төгрөгөөр баталж 39,204.0 мянган төгрөгийг зарцуулж 80,5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 85,18 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 278,520.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 483,985.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 173,7 хувь буюу 205,465.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Гурванбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Гурванбулаг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо		Аудитын санал дүгнэлтийн төрөл							
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Бүгд	Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1		1						
ИТХурал	1	1		1						
ОНХС	1	1		1						
СХС	1	1		1						
НИЙТ ДҮН	4	4		4	0	0	0			0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 53,723.9 мянган төгрөгийн алдаа, 53,723.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
	Тоо	Дүн	Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Санхүүгийн тайлангийн зөрчил									
ЗДТГ	1	-						1		-
ОНХСан	1	53,723.9			1	53,723.9				
Нийт дүн	2	53,723.9			1	53,723.9		1		-

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 53,723.9 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн байна.

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		-			
1	"Эвт уран санаа"ХХК-аас 3,200.0 мянган төгрөгийн үнэтэй мотоцикл худалдан авсан бөгөөд улсын дугаар гэрчилгээг аваагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Р.Гантулга Б.Дэлгэрдалай
Орон нутгийн хөгжлийн сан		53,723.9			
1	Сангийн хөрөнгөөр Цаг уурын талбайг стандартын болгох ажлыг хийхээр "Нью бест хаус" ХХК нь 2023.09.15-2023.12.30-ний хооронд гүйцэтгэхээр 97874000 төгрөгөөр гэрээ байгуулж, 53,723,916 төгрөгийг олгосон боловч 2023.12.18-ны байдлаар ажил эхлээгүй байна.	53,723.9	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Жавхлан Б.Няммэший
Нийт дүн		53.723.9			

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____ оОо _____